

**ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
АЖЛЫН АЛБАНААС 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх үр дүн
Зорилт 1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны үйл ажиллагааг аймгийн хөгжлийн зорилтуудыг өндөр түвшинд хэрэгжүүлэхэд чиглүүлэн хүртээмжтэй зохион байгуулан, хуралдааны шийдвэрийн хэгжилтийг хангуулна.					
1.1	Аймгийн эдийн засаг нийгмийн амьдралын аль ч асуудлаар санаачилсан асуудлыг судалж хуулийн дагуу шийдвэрлэн ажиллах	2,4 дүгээр улиралд	Д.Баттулга Б.Алтанбаяр	Аймгийн ИТХ-ын ажлын алба	Аливаа тулгамдаж буй асуудал шийдвэрлэгдэхэд нөлөөлсөн байна.
Зорилт 2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны үйл ажиллагааг шуурхай хангаж, ИТХ-д хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд орон нутаг болон иргэдийн ашиг сонирхолд нийцүүлсэн бодлого боловсруулж оновчтой шийдвэр гарган ажиллана.					
2.1	Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	1-р сард Жилдээ	М.Цэрэндаваа	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Тэргүүлэгчид	Үйл ажиллагааны төлөвлөгөө бүрэн хэрэгжиж үр дүн гарсан байна.
2.2	Аймгийн ИТХ-ын ажлын албаны ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулах	1-р сард	Т.Гантулга	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Тэргүүлэгчид	Хурлын чиг үүргийг өргөн хүрээнд нарийвчлан тусгаж зохицуулан, хуралд үйлчлэх бүтэц бий болсон байна.
2.3	Хурлын хороод болон төлөөлөгчийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх, ажиллах нөхцөлд нь дэмжлэг болох тухай журмыг хэлэлцэж батлах	1-р сард	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Тэргүүлэгчид	Журмыг хэрэгжүүлсэнээр төлөөлөгч, хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх ажиллах нөхцөл болоцоонд дэмжлэг үзүүлэх болож бүрдэнэ.
2.4	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих Иргэний зөвлөлийг шинэчлэн байгуулан ажиллуулах	1-р сард	Б.Энхээ Э.Гантулга Т.Гантулга	Аймгийн ИТХ-ын ажлын алба, аймгийн Цагдаагийн газар	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоог идэвхжүүлэн, цагдаа олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулсан байна.

2.5	Төрийн дээд шагнал, одон медальд тодорхойлсон шагналын баримт бичгүүдийг хүлээн аван хэлэлцэж дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх	Жилийн турш	Э.Гантулга	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Аймгийн ЗДТГазар, Сумдын ИТХ	Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилж шагнуулна
2.6	2017 онд Алдарт эх одонд тодорхойлогдох эхчүүдийн материалыг хянаж Тэргүүлэгчдийн хуралд танилцуулах	Жилийн турш	Э.Гантулга М.Цэрэндаваа	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Аймгийн ЗДТГазар, Сумдын ИТХ	Монгол улсын Ерөнхийлөгчид уламжилж шагнуулна.
2.7	Шашны байгууллагуудын зөвшөөрлийн асуудлыг журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэх	Жилдээ	Э.Гантулга	Аймгийн ИТХ-ын ажлын алба	Шашны байгууллагуудын үйл ажиллагаа сайжирна.
2.8	Байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийн дагуу ажлын хэсэг гаргах болон хороодыг томилж хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан дүнг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэр гаргах	Жилдээ	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Нутгийн удирдлага, өргөдөл, гомдол, хяналт үнэлгээний бодлогын хороо	Хяналт шалгалтын ажлын үр дүн сайжирна.
2.9	Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд хурлын төлөөлөгч, тэргүүлэгч, аймгийн Засаг даргаас санаачилсан асуудлуудыг зохих хууль тогтоомжийн дагуу судалж шийдвэрлэх	Жилийн турш	Ажлын алба	Төлөөлөгч, Тэргүүлэгч, Хороод, Аймгийн ЗДТГ	Хурлын төлөөллийн болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох, хяналтын чиг үүргийг хуулийн дагуу санаачилгатай хэрэгжүүлж Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө сайжирсан байна.

Зорилт 3. ИТХ-ын үйл ажиллагаа, гарсан шийдвэрийг олон нийтэд шуурхай хүргэж, иргэдийг мэдээлэлжүүлэх замаар оролцоог дээшлүүлнэ.

3.1	Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс бүрэн эрхийн хугацаанд хийсэн ажлыг иргэдэд мэдээлэх, иргэдийн санал, хүсэлтийг сонсож хүлээн авах өдөрлөгийг сумдад зохион байгуулах	4, 9-р сард	Б.Алтанбаяр Т.Гантулга	Аймгийн ИТХ-ын ажлын алба,	Иргэдийг мэдээллээр хангаж санал хүсэлтийн хүлээн авснаар цаашдын ажиллагааг оновчтой төлөвлөж иргэдийн оролцоо нэмэгдэнэ.
3.2	Шилэн дансны цахим хуудсанд тавигдах байгууллагын төсөв, санхүүгийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан иргэдэд мэдээлэх	Сар бүр	Д.Баттулга	Аймгийн ИТХ-ын ажлын алба,	Төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа иргэдэд ил тод нээлттэй болж, тэднээс тавих хяналт сайжирна.

3.3	Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонголын тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Төсвийн тухай болон бусад иргэдийн оролцоог дэмжсэн хуулиудын хэрэгжилтийг хангаж шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангаж иргэдэд эргэж мэдээлж ажиллах	Жилийн турш	Б.Алтанбаяр Т.Гантулга Э.Гантулга	Аймгийн ИТХ-ын ажлын алба,	Хурлын шийдвэрүүд эрх зүйн үндэслэлтэй, оновчтой гарч иргэдийн оролцоо дээшилсэн байна. Хууль тогтоомжуудыг сурталчилсан байна.
3.4	Хурлын хороод бүр 1-2 удаа өөрсдийн санаачилсан ажлыг зохион байгуулан тэргүүлэгчдэд тайлагнан дүгнүүлж, иргэдэд сурталчлах	Жилдээ	Б.Алтанбаяр Т.Гантулга	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Хурлын бүх хороод	Хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэн тэдний үйл ажиллагааны үр дүн, урамшууллын тогтолцоог бий болгоно.
Зорилт 4. Хэлэлцүүлэг, сургалт, мэдээлэл зэрэг сурталчилгааны ажлуудын чанар хүртээмжийг дээшлүүлэн Хурал, иргэдийн хамтын ажиллагааг бодит түвшинд сайжруулна.					
4.1	Сумын ИТХ-ын төлөөлөгч, НБД нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Жилдээ	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Сумдын ИТХ	ИТХ-ын төлөөлөгчдөд үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, мэдээллийг олгож идэвхжүүлнэ.
4.2	Аймгийн ИТХ-ын вэб сайт, Khural.mn дэд цахим хуудасны байнгын ажиллагааг хангаж, хурлын бүхий л мэдээ, мэдээлэл, шийдвэр, тайланг шуурхай байршуулж олон нийтэд хүргэх	Тухай бүр	Т.Гантулга	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Хурлын хороод, Сумын ИТХ	Мэдээ мэдээллийн хүртээмж, эргэх холбоо сайжирна.
4.3	Олон нийтийн "Social media" хэрэгслээр аймгийн ИТХ-ын үйл ажиллагааг сурталчлах (Facebook, twitter... гэх мэт)	Тухай бүр	Б.Алтанбаяр Т.Гантулга	Хамтран ажиллагч телевизүүд	Иргэдийн санал хүсэлтийг саадгүй хүлээн авна. Мэдээллийн бааз суурь өргөжинө.
4.4	Орон нутгийн телевизүүдтэй хамтын ажиллааны гэрээ байгуулан ажиллахдаа төлөөлөгчдөөр мэдээлэл хийлгэж ажиллахад түлхүү анхаарах	Жилдээ	Б.Алтанбаяр Т.Гантулга	Хамтран ажиллагч телевизүүд	Мэдээллийн хүртээмж сайжирч, төлөөлөгч иргэдийн эргэх холбоо сайжирна.
4.5	Орон нутгийн болон иргэдийн санал болгосон тулгамдсан асуудлуудаар хэлэлцүүлэг зохион байгуулан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр ажиллах	Улирал бүр	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Хурлын хороод, АЗДТГ	Аймгийн эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлууд хөндөгдөж тодорхой шийдэл, үр дүнд хүрсэн байна.

4.6	Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрүүд үүнтэй холбоотойгоор хэрэгжүүлсэн ажлуудыг багцлан телевизийн нэвтрүүлэг бэлтгэх	2 дугаар улиралд	Б.Алтанбаяр Т.Гантулга	Хамтран ажиллагч телевизүүд /студи/	Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэрүүд үүнтэй холбоотойгоор хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтын ажлыг олон нийтэд сурталчилсан байна.
4.7	Иргэдийг соён гэгээрүүлэх, хандлагыг өөрчлөн идэвхжүүлэх, шинэлэг мэдээллээр хангах зорилгоор тодорхой сэдвүүдээр сургалт, лекц зохион байгуулах	Сар бүр	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Хурлын хороод, Сумын ИТХ	Иргэд тодорхой сэдвээр шинэ мэдлэг мэдээлэл олж авсан байна.
4.8	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Цагаатгах ажлыг удирдах зэрэг ажлуудыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулан хэрэгжүүлнэ.	Жилдээ	М.Цэрэндаваа	Аймгийн ИТХ-ын ажлын алба, аймгийн ГХУСАЗСЗ, Сумын ИТХ,	Хуулиар олгогдсон ИТХ-ын чиг үүргүүдийн хэрэгжилт сайжирна.
Зорилт 5. Хяналт шалгалтын ажлын үр дүнг дээшлүүлэн хуулийн хэрэгжилт, аймгийн эдийн засгийн чадавхыг сайжруулахад нөлөөлж ажиллана.					
5.1	Байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийн дагуу ажлын хэсэг гарган хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах	Тухай бүр	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Холбогдох хороод	Хяналт шалгалтын ажлын үр дүн сайжирна.
5.2	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын өргөдөл, гомдол барагдуулсан байдал, төлөөлөгч нарт хандаж ирүүлсэн өргөдөл гомдлын байдал дээр судалгаа явуулж дүгнэлт гаргах	Тухай бүр	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Нутгийн удирдлага, өргөдөл, гомдол, хяналт үнэлгээний бодлогын хороо	Нийгмийн тулгамдсан асуудлыг судалж илрүүлэн цаашдын үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлно. Хяналт шалгалтын ажлын үр дүн сайжирна.
5.3	Уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн ажлын үр дүн, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавих	10-р сард	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Бүх хороод	Мэргэжлийн байгууллага оролцсон ажлын хэсэг ажиллуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Зорилт:6. Хурлын ажлын албаны шуурхай байдлыг ханган төлөөлөгч, тэргүүлэгчдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулж мэдээлэл солилцоонд шинэлэг арга зүйг ашиглана.						
6.1	Хуралдаан болон Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудлын төсөл, гарсан шийдвэр, бусад мэдээллийг төлөөлөгчдөд түргэн шуурхай хүргэх, саналыг нь авах, эргэх холбоог сайжруулах олон сувгийг ашиглахаас гадна тэднийг хариуцлагажуулж ажиллах	Жилийн турш	Ажлын алба	Аймгийн ажлын алба	ИТХ-ын	Хуралдааны дэгийн хэрэгжилт, төлөөлөгчдийн хариуцлага дээшилж, гарч буй шийдвэрийн чанар, төлөөлөгчдийн оролцоо сайжирч, эргэх холбоо, хамтын ажиллагаанд ахиц гарсан байна.
6.2	ИТХ, Тэргүүлэгчдийн хурлаас баталсан тогтоолуудаар цахим архив үүсгэн иргэд, байгууллагад өгөх лавлагааны үйлчилгээг сайжруулах	Жилийн турш	Ажлын алба	Аймгийн ажлын алба	ИТХ-ын	Архиваас мэдээлэл, баримт шүүхэд хурдан шуурхай болно.
6.3	Сумын ИТХ-ын гаргаж буй тогтоол шийдвэр, хуралдааны баримт бичгүүдэд хяналт шинжилгээ үнэлгээг хийж холбогдох зөвлөмжийг өгөх	Жилийн турш	Ажлын алба	Аймгийн ажлын алба, ИТХ	ИТХ-ын Сумын	Сумын ИТХ-д мэрэгжил арга зүйн зөвлөгөөг өгч хурлын байгууллагын чадавхыг сайжруулна.
6.4	Гадаад харилцаа, түншийн хамтын ажиллагааг өргөжүүлэн үр ашигтай ажлуудыг хамтран зохион байгуулах	Жилийн турш	Ажлын алба	Аймгийн ажлын алба	ИТХ-ын	Хамтын ажиллагааны хүрээнд тодорхой үр дүнг гаргана.
6.5	Хамтран ажилладаг гадаад, дотоодын байгууллагуудын холбогдох бүхий л мэдээллийн санг бий болгох, хамтын ажиллагааг сайжруулах	Жилийн турш	Ажлын алба	Аймгийн ажлын алба	ИТХ-ын	Мэдээллийг шуурхай солилцож
6.6	Гадаад, дотоодын зочид, төлөөлөгч нарт хүндэтгэл үзүүлэхэд ашиглах байгууллагын бэлэг дурсгалын зүйлтэй болох	1 дүгээр улирал	Б.Алтанбаяр Э.Гантулга Т.Гантулга	Аймгийн ажлын алба	ИТХ-ын	Байгууллагын соёл, ёслолын үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болсон байна.
6.7	Аймгийн ИТХ-ын дарга болон ИТХ, Тэргүүлэгчдийн хурлаас гарсан тогтоол шийдвэрээр ном гаргах	1 сардаа	Б.Алтанбаяр Э.Гантулга Т.Гантулга	Аймгийн ажлын алба	ИТХ-ын	
6.8	Аймгийн ИТХ-аас санаачлан "Цэцэрлэгт хүрээлэн"-г байгуулах	Жилийн турш	Ажлын алба, Хурлын төлөөлөгч нар	Аймгийн ажлын алба,	ИТХ-ын Хэрлэн сумын ЗДТГ,	Иргэдийн амралт чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэх орчин нөхцөл бүрдэнэ.

6.9	Ажлын албаны ажилтнуудыг чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтад ээлж дараатай хамруулах	1-4 дүгээр улиралд	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын ажлын алба	Ажлын албаны чадавх, мэргэжил арга зүй дээшилснээр ажлын бүтээмж сайжирна.
7. Бусад					
7.1	Зарим аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны туршлага судлах	8 сард	Ажлын алба	Аймгийн ИТХ-ын ажлын алба	Ажлын албаны ажлын бүтээмж сайжирна.

ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ